

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН 2025 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны 12 дугаар сарын 15

Номлон

№	Дотоод хяналт шалгалтын чилгэл	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилгот түвшин	Хэрэгжилт	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7
1	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Дотоод хяналтын ажлын хэсгийн 2023, 2024 оны зөвлөмжийн хэрэгжилт	Хяналт-шалгалт хийсэн зөвлөмжийн тоо	0	4	"Тэрбум мод" хөтөлбөрийн хүрээнд улс, орон нутгийн төсөөс зарцуулсан хөрөнгийн үр дүнд хийсэн аудитын тайлан, "Баянхонгор аймгийн шинэ суурьшлын бүсэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа арга хэмжээ, бүтээн байгуулалт"-д хийсэн аудитын тайлан, "Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт"-д хийсэн аудитын тайлан, "Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө"-нд хийсэн аудитын тайлан, "Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн аудитын тайлан, Баянхонгор аймгийн ЗДТГ-ын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлан зэрэг 5 аудитын тайлангийн аудитын төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн хариуг тогтоосон хугацаанд хүргүүлж ажилласан байна.	100%
2	Засаг даргын нөөц хөрөнгийн 2025 оны төсөв, гүйцэтгэл	Нөөц хөрөнгө зарцуулах шийдвэрийг зарцуулалттай тулгасан шалгах хуудас, дүгнэлт гаргасан эсэх /Тийм-1, үгүй-0/	0	1	Дотоод хяналт, шалгалт зохион байгуулах ажлын хэсэг"-ийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн Засаг даргын 2025 онд батлагдсан нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтад хяналт шалгалт хийхэд 2025 оны 06 дугаар сарын 25-ны байдлаар 70 захирамж гарч 659,808,552 төгрөг буюу нийт төсвийн 73 хувийг зарцуулсан байна. Захирамж тус бүрийг зориулалтаар нь ангилж, нөөц хөрөнгийн	100%

1	2	3	4	5	6	7
					Зарчууллагын талаар анхаарах асуудлыг 2025 оны 08 дугаар сарын 06 өдрийн 38 тоот илтгэх хуудсаар Засаг даргын Тамгын газрын даргад танилцуулсан.	
3	Байгууллагын худалдан авалтын гэрээний үүргийн гүйцэтгэл	Гэрээний үүргийн шалгах хуудас, дүгнэлт гаргасан эсэх Лийм-1, Угуй-0/	0	1	Байгууллагын 2025 оны худалдан авалтын тендерийг шатах тослох материал, бичиг хэргийн материалаар зарлаж, "НИС"ХХК, "Хадат бодь" ХХК-тай байгуулан ажиглаа. Шатах тослох материалын зардалд төлөвлөсөн зардал 100.0 сая байсан ба тодотголоор 76.0 сая болгон бууруулсан ба одоогоор гүйцэтгэл 94.7%-тай, бичиг хэргийн зардалд 36.0 сая төгрөг төлөвлөснөөс тодотголоор 31,3 сая болгон бууруулсан ба гүйцэтгэл 103,2% болж хэтэрсэн байна. Зардал хэтэрсэн шалтгаан нь батлагдсан төсөв буурсан, Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгтэй холбогдуулан зардал тус тус өссөн байна.	100%
4	Төрийн үйлчилгээний болон гэрээт албан хаагчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, түүний Биелэлт /2024, 2025/	Гэрээний үүргийн шалгах хуудас, дүгнэлт гаргасан эсэх Лийм-1, Угуй-0/	0	1	Аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2025 оны 07 дугаар сарын 01 өдөр нийт 33 хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулсан байна. Гэрээ байгуулахдаа хөдөлмөрийн гэрээний гол нөхцөлийг тусгасан, гэрээний нэмэлт нөхцөл дээр өөрчлөх 2 заалт орсныг залруулахаар Тамгын газрын даргад зөвлөмж хүргүүлэв	100%
5	Байгууллагын орчны стандарт	Стандартын хэрэгжилтийг шалгах хуудас, дүгнэлт гаргасан эсэх Лийм-1, Угуй-0/	0	1	Аймгийн Засаг даргын Тамгын газрын орчны стандартын хэрэгжилтэд Монгол Улсын 4 стандартын хүрээнд 41 үзүүлэлтээр дүгнэхэд 12 үзүүлэлт буюу 31 хувь нь стандарт шаардлагад нийцээгүй байна. Хяналтын явцад хөгжлийн барьшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдал муу, үерээс хамгаалах босооны ус зайлуулах байгууламж төлөвлөгдөөгүй, зам, замын байгууламжийн хувьд зогсоолын тоо стандартад нийцсэн, авто замын гарцыг авто замын хөдөлгөөн болгон явган	100%

1	2	3	4	5	6	7
					<p>зорчигчийн хөдөлгөөнтэй уялдсан, унадаг дуулин зогсоол шийдэгдсэн байна. Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламж, Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө, хаяг, хаяржилт, гэрэлтүүлэг чимэглэл, хог хаягдал түр хадгалах цэг, аюулгүй байдал, гэрэлтүүлэг камержуулалт стандартын шаардлагад нийцсэн байна.</p>	
6	Албан хаагчдын ажлын хэсэгт ажилласан бүртгэл	Бүртгэл гаргасан эсэх /тийм-1, үгүй-0/	0	1	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын алба хаагчдаас аймгийн Засаг даргын захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар томилогдон ажиллаж байгаа зөвлөл, хороо, ажлын хэсгийн бүрэлдэхүүний судалгааг авч нэгтгэсэн. Судалгаанд дүн шинжилгээ хийж төрийн албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.</p>	100%
7	Цахим системийн ашиглалтын бүртгэл	Бүртгэл гаргасан эсэх /тийм-1, үгүй-0/	0	1	<p>Төрийн байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн систем ERP-д аймгийн Засаг даргын Тамгын газрын 89 алба хаагч бүртгэлтэй байна. Системийн албан бичиг модулийг 7 хэлтсийн дарга, 56 албан хаагч өдөр тутмын үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж хэвшсэн. Тайланд хугацаанд Аймгийн Засаг даргын 1098, Засаг даргын Тамгын газрын 1457, нийт 2555 албан бичиг боловсруулж ERP системээр 75.4 хувь буюу 1927 албан бичгийг холбогдох газруудад хүргүүлсэн байна. Аймгийн Засаг даргын Тамгын газарт нийт 6096 албан бичиг ирснээс 4405 албан бичиг буюу 72.3 хувийг ERP системээр хүлээн авсан байна. Үүнээс хугацаатай албан бичиг 265 ирснийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.</p> <p>еoffice.baunhanolnog.gov.mn цахим системд нийт 68 алба хаагч бүртгэлтэй байна. Тайланд хугацаанд системээр нийт Аймгийн</p>	100%

